

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол ардын намын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Цахим хаяг: info@mindug.mn Улаанбаатар хот. 2025 он	Миндүг аудит ХХК-ийн	
	Гүйцэтгэх захирал:	С.Энхтөр
	Утас: 95957791	Цахим хаяг: Director@mindug.mn
	Аудитын менежер:	Г.Уранбилэг
	Утас: 99029193	Цахим хаяг: info@mindug.mn
	Аудитор:	Б.Бүзмаа, Л.Оюунбилэг
		Цахим хаяг: buzmaa@mindug.mn
		Аудиторын туслах: Т.Цагаанбаяр, Н.Ичинхорлоо
		Хуулийн зөвлөх: Л.Золбоо, Ц.Номингоо

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Зөвлөмж	8
3.2 Зөвлөмж	8
3.3 Зөвлөмж	8
3.4 Зөвлөмж	9
3.5 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 25-Т/01

Улаанбаатар хот

“МОНГОЛ АРДЫН НАМ”-ЫН УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

Дүгнэлт

Бид “МОНГОЛ АРДЫН НАМ”-ын /цаашид нам гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “МОНГОЛ АРДЫН НАМ”-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн гаргасан Сангийн сайдын заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү аудитын тайлангийн Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Намаас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно. Цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэсэн төсөөллөөр тайлангаа бэлтгэсэн байна.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Хийморь хотхон, 4-7 байр, 7-1 тоот
Утас: 91160110, 95957791
И-Мэйл: info@mindug.mn, director@mindug.mn



Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Бусад мэдээлийн хувьд удирдлага хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайланд орсон боловч бидний гаргасан аудиторын тайланд ордоггүй. Бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилт гаргадаггүй.

Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу гаргаж, үнэн зөв толилуулах нь бидний үүрэг хариуцлага бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь намын тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, намаа татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь намын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бид хийж гүйцэтгэсэн аудитаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил болно. Аудитын явцад тус намд хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв. Мөн бид мэргэжлийн үл итгэх байдлыг баримтлан ажилласан. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авна.
- Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их

байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг орно.

- Намын дотоод хяналтын үр ашигтай байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаарх ойлголт олж авдаг.
- Намын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол, тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Намын тасралтгүй байх зарчимд материаллаг тодорхойгүй байдалд эргэлзээ үүссэн бол тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулж, тодруулгад хангалттай дурдаагүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудитын тайлан гарах өдөр хүртэл олж авсан баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргасан.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлсон.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Улс төрийн намын тухай” хууль /шинэчилсэн найруулга/-ын 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Сонгуулийн төв байгууллага болон тус улс төрийн намын удирдлагад зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж, аудитын тайланг бэлтгэсэн болно.



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Санхүүгийн байдлын зүйл	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,154,865,666.04	328,364,641.35
Авлага	471,725,775.38	880,736,838.85
Бараа материал	76,953,831.30	64,325,099.30
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	-	1,357,822.27
Бусад эргэлтийн хөрөнгө	20,444,963.00	15,048,963.00
Нийт эргэлтийн хөрөнгө	1,723,990,235.72	1,289,833,364.77
Үндсэн хөрөнгө (цэвэр)	31,345,276,684.15	31,401,536,689.15
Биет бус хөрөнгө	77,742,540.00	77,742,540.00
Нийт эргэлтийн бус хөрөнгө	31,423,019,224.15	31,479,279,229.15
НИЙТ ХӨРӨНГӨ	33,147,009,459.87	32,769,112,593.92
Татварын өр	196,737,171.79	465,706,829.83
НДШ-ийн өр	126,328,634.84	527,908,160.51
Богино хугацаат өр төлбөр	2,063,129,812.85	1,792,093,132.00
Нийт өр төлбөр	2,386,195,619.48	2,785,708,122.34
Өмч	22,973,194,447.88	22,973,194,447.88
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,755,617,700.00	4,755,617,700.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,032,001,692.51	2,254,592,323.70
Нийт эздийн өмч	30,760,813,840.39	29,983,404,471.58
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	33,147,009,459.87	32,769,112,593.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Орлого зардлын зүйл	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Намын гишүүний татвар	546,369,049.00	402,443,751.08
Сонгуульт гишүүний татвар	2,775,502,948.00	3,508,932,628.89
Мөнгөн хандив	333,390,000.00	89,786,290.00
Мөнгөн бус хандив		5,000,000.00
Төрийн санхүүжилт	603,333,333.00	-
Төслийн санхүүжилт	1,795,665,000.00	-
Намын өөрийн орлого	2,973,721,131.64	4,642,863,998.64
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	9,027,981,461.64	8,649,026,668.61
Ажиллагсдын зардал	4,892,647,098.23	5,963,437,138.34
Үйл ажиллагааны урсгал зардал	3,211,372,121.54	3,686,923,458.79
Үйл ажиллагааны зардлын нийт дүн	8,104,019,219.77	9,650,360,597.13
Үйл ажиллагааны үр дүн (1-2)	923,962,241.87	-1,001,333,928.52
Бусад гарз	350,950,304.90	
Татварын өмнөх ашиг, алдагдал	573,011,936.97	-1,001,333,928.52
Татварын дараах ашиг, алдагдал	573,011,936.97	-1,001,333,928.52
Тайлант үеийн ашиг, алдагдал	573,011,936.97	-1,001,333,928.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
Мөнгөн орлогын дүн	10,041,511,347.26	8,361,490,614.42
Намын гишүүний татвар	546,369,049.00	402,443,751.08
Сонгуульт гишүүний татвар	2,775,502,948.00	3,401,932,628.89
Иргэний өгсөн мөнгөн хандив	295,338,000.00	61,786,290.00
Хуулийн этгээдийн өгсөн мөнгөн хандив	15,760,000.00	28,000,000.00
Төрийн санхүүжилт	603,333,333.00	
Төслийн санхүүжилт	1,795,665,000.00	
Өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар олсон орлого	4,009,543,017.26	4,467,327,944.45
Мөнгөн зарлагын дүн	9,255,581,390.67	9,131,191,639.11
Ажилчдад төлсөн	3,772,297,839.82	5,403,212,687.83
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
Бараа материал худалдан авахад	2,544,627,008.18	300,613,356.16
Ашиглалтын зардалд төлсөн	501,350,726.51	590,931,113.71
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	841,922,907.77	487,660,891.87
Бусад мөнгөн зарлага	1,595,382,908.39	2,348,773,589.54
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	785,929,956.59	- 769,701,024.69
Мөнгөн зарлагын дүн	38,289,500.00	56,800,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	38,289,500.00	56,800,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 38,289,500.00	- 56,800,000.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	747,640,456.59	- 826,501,024.69
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	407,225,209.45	1,154,865,666.04
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,154,865,666.04	328,364,641.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн зүйл	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12 дугаар сарын 31	22,973,194,447.88	4,755,617,700.00	2,458,989,755.54	30,187,801,903.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	573,011,936.97	573,011,936.97
2023 оны 12 дугаар сарын 31	22,973,194,447.88	4,755,617,700.00	3,032,001,692.51	30,760,813,840.39
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	1,001,333,928.52	1,001,333,928.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	223,924,559.71	223,924,559.71
2024 оны 12 дугаар сарын 31	22,973,194,447.88	4,755,617,700.00	2,254,592,323.70	29,983,404,471.58

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 160.4 сая төгрөгийн 3 алдаа¹, 5 зөрчил илэрснээс аудитын явцад 160.4 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 5 зөрчилд алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар нийт 160.4 сая төгрөгийн 3 алдаа² илэрснээс аудитын явцад 160.4 сая төгрөгийн алдааг залруулж, 86.4 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд: 1. Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдэл 74.0 сая төгрөгийн зөрүүтэй.

2. Баянхонгор аймгийн салбарын 86.4 сая төгрөгийн Намын гишүүний татварын орлогыг кассын тайланд харилцах данснаас авсанаар буруу бүртгэн тайлан гаргасан. НББОУС 18 Орлого, СТОУС15 Худалдан авагчтай хийсэн гэрээний орлого батламж мэдэгдлийг хангаж ажиллах, алдааг давтахгүй байх зөвлөмж өглөө.

3. 25 салбар хороодын санхүүгийн тайланд тусгагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан алдаатай тайлагнасан. СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан батламж мэдэгдлийг хангаж ажиллах.

Аудитаар нийт 5 зөрчил³ илэрснээс, 5 зөвлөмж өгсөн. Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

- 15 харилцагчтай холбоотой өглөг, авлага он дамжин эргэлтийн хөрөнгө, өр төлбөрөөр бүртгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 12-р зүйлийн 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; зүйл заалт, 20-р зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; НББОУС 13 Эргэлтийн хөрөнгө ба эргэлтийн өр төлбөрийн толилуулга батламж мэдэгдлийн хангахгүй байна. батламж мэдэгдэл хангаж ажиллах.

3.2 Зөвлөмж

- Биет бус хөрөнгө, үндсэн хөрөнгийн хорогдол, элэгдлийн зардал тооцоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; заалт, НББОУС 16 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн батламж мэдэгдлийн хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

- 465.7 сая төгрөгийн ХХОАТ-ын өртэй толилуулсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ААНОАТ-ын тухай хуулийн 24-р зүйлийн 24.6.Суутган ногдуулсан албан татварыг ажлын 10 өдрийн дотор төсөвт шилжүүлнэ зүйл заалтыг хангахгүй байна.

3.4 Зөвлөмж

- Нийгмийн даатгалын 527.9 сая төгрөгийн өрийг тайланд толилуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21-р зүйл 21.1.Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө зүйл заалт батламж мэдэгдлийг хангаагүй.

3.5 Зөвлөмж

- Анхан шатны баримт цахим баримтаар бүрэн нотлогдоогүй байна

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн 5.1.4.үнэн зөв байх; 5.1.6.зохицох. 13-р зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сонгуулийн ерөнхий хороонд 2025 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайлан эхний үлдэгдэл зөрүүтэй. 25 салбарын ӨӨТ алдаатай.	2	74.0			2	74.0	2	74.0				
Баянхонгор аймаг орлогын эх үүсвэр буруу тайлагнасан	1	86.4			1	86.4	1	86.4				
Дүн	3	160.4			3	160.4	3	160.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын б-гад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Биет бус хөрөнгө, үндсэн хөрөнгийн хорогдол, элэгдлийн зардал тооцоогүй	1						1					
70 харилцагчтай холбоотой өглөг, авлага он дамжин эргэлтийн хөрөнгө, БХӨ төлбөрөөр бүртгэгдсэн	1						1					
Анхан шатны баримт цахим баримтаар бүрэн нотлогдоогүй	1						1					
Дүн	3						3					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ХХОАТ-ын өр төлбөрийг хугацаанд нь төлөөгүй	1						1	
Дүн	1						1	
Нийгмийн даатгалын хэрэгжилттэй холбоотой зөрчил								
НДШ-ийн өр төлбөрийг хугацаанд нь төлөөгүй	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн	2						2	